

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалт, “БиДиСек” ХК-иас 2008 оны 6 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“БиДиСек” ХК-д үнэт цаасны зах зээлд андеррайтерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2008 оны 6 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай олгосугай.

2.Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллахыг “БиДиСек” ХК /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ